

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

2025.07.21

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны хэрэгжилтэд эхний хагас жилийн явцын хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Үйл ажиллагаанд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ыг үндэслэл болгов.

Танилцуулга

Зам, тээврийн яамны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө болон шийдвэрийн хэрэгжилт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэг 11 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 77.2 хувьтай байна.

Үнэлэлт, дүгнэлт:

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам"-ын дагуу Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө болон шийдвэрийн хэрэгжилт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэг 11 үйл ажиллагааны хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагаанд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 11 үйл ажиллагааны 1,386 арга хэмжээний дундаж үнэлгээ **75.5** хувь байна.

Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 12 зорилтын 90 арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар дунджаар **77.5** хувьтай үнэлэгдсэн байна. Энэ нь өмнөх улирлын үнэлгээнээс 16.8 хувиар өссөн байна.

Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 12 зорилтын 90 арга хэмжээний шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшинг алдаатай тодорхойлсон ба гүйцэтгэлийн төлөвлөгөөг ХШҮДАГ-аар санал, зөвлөмжийн дагуу төлөвлөөгүй улмаас нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө нь яамны төлөвлөгөөнөөс хүрэх түвшин багассан, хэрэгжих хугацааг хойшлуулсан зэрэг алдаа гарсан байна.

Санал, зөвлөмж:

Хөрөнгийн асуудалтай болон хөрөнгө шийдэгдээгүй арга хэмжээнүүдийг бусад арга замаар хөрөнгө оруулалтыг шийдэх чиглэлээр идэвх санаачилгаатай ажиллах, 2025 оны төсвийн тодотголд хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, он дамжин хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг бүрэн тусгуулах санал хүргүүлэх чиглэлээр онцгойлон анхаарч ажиллах Төрийн захиргааны удирдлагын газарт ;

Төсөв хөрөнгө шаардлагагүй салбарын хуулиудыг шинээр болон шинэчлэн боловсруулах, журам, дүрэм, төлөвлөгөө, хөтөлбөр батлуулах, программ хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, үнэлгээний хорооны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр анхаарч, зорилтод түвшин болон төлөвлөсөн хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг яамны дотоод нэгжүүдэд;

Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тасарсан буюу 0 хувийн биелэлттэй 1, 30 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ, 50 хувийн биелэлттэй 14 арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй тул эдгээр арга хэмжээг эрчимжүүлэн ажиллахыг яамны дотоод нэгжүүдэд;

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор "Хяналт-шинжилгээ хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Үнэлгээ хийх журам"-ыг 2 дугаар хавсралт, "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус батлагдсан тул Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг шинэчлэн батлуулж, 2025 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааг дүгнэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт;

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-д байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрийг хувиар илэрхийлж дүгнэх тул төлөвлөгөөний суурь түвшин болон хүрэх түвшинг тоо нь утгаар илэрхийлэхүйц төлөвлөн, яам болон түүний дотоод нэгжүүдийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг, шинэчлэн батлуулах ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

Албан хаагч бүр өөрийн хариуцсан арга хэмжээг тоо баримттай, 2000 тэмдэгтэд багтаан, заасан хугацаанд бүрэн тайлагнах, нэгжийн дарга нар тэдгээр арга хэмжээг бүрэн хянаж, баталгаажуулан ажиллахыг тус тус зөвлөж байна.

ХШҮДАГ

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилт хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	90	86	77,5
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	54	52	51,8
3	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	53	51	44,9
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	312	292	84,7
5	Сайдын тушаалын биелэлт	372	360	70.3
6	ТНБД-ын тушаалын биелэлт	326	322	85.2
7	Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө хэрэгжилт	13	11	100,0
8	Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээс гарсан үүрэг даалгаврын хэрэгжилт	22	22	100,0
9	Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт	19	19	67,4
10	Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилт	46	46	80,2
11	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	81	80	87,7
Нийт		1386	1341	77.2

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН
/графикаар/

Дундаж үнэлгээ 75.5%

